



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Э.ЭРДЭНЭСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.07.23 № 05/6104  
танай 2018.07.10-ны № 1/022 -Т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Оюуны өмчийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Сүрэнжавын Ганзориг, мөн хэлтсийн мэдээлэл, сурталчилгаа, сургалт хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Дашбэмбэрэлийн Гэрэл, Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Сумъяагийн Урангэрэл, мөн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн-архивчаар томилогдохоор нэр дэвшсэн Пэрэнлэйн Ганзориг, барааны тэмдгийн шинжээчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ганзоригийн Эрдэнэцэцэг, Хяналтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Батжаргалын Бадамцэцэг, мөн хэлтсийн улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Даваадоржийн Наранбаатар, Даваасамбуугийн Бат-Эрдэнэ нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан бусад хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж, уг албан тушаалд томилогдсоны дараа хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд цахимаар мэдүүлэх үүрэгтэй болохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Х.ХАШБААТАР



0010331